



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН "НЭЭЛТИЙН ЁСЛОЛЫН
АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Арга хэмжээний зорилго:

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн “Нээлтийн ёслолын ажиллагаа”-г ёслол төгөлдөр зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн нийт элсэгч, суралцагч, эрдэмтэн багш нар оролцоно.

Хугацаа: Үндсэн үйл ажиллагаа ШУТИС-ийн төв байрны 3 давхрын “Хурлын танхим”-д 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр 11:00-12:00 цагт болно.

Үйл ажиллагааны зохион байгуулалт:

- Нээлтийн ёслолын ажиллагаа танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.
- Танхимын үйл ажиллагаа ШУТИС-ийн төв байрны 3 давхрын хурлын танхимд болох бөгөөд шинээр элсэгчдийн төлөөлөл, профессор багш нар урилгаар оролцоно.
- Бусад элсэгчид, суралцагч оюутнууд, эрдэмтэн багш нар тухайн өдрийн 11-12 цагийн хооронд хуваарийн дагуу лекц, семинарын ангиас нээлтийн үйл ажиллагаанд цахимаар оролцоно.
- Орон нутгийн бүрэлдэхүүн, харьяа сургуулиуд аймаг орон нутаг, өөрсдийн онцлогоос шалтгаалан нээлтийн ёслолын ажиллагааг 2023 оны 09-р сарын 01-ний өдөр зохион байгуулж болно.

Шууд дамжуулалт: ШУТИС-ийн пэйж хуудсаар шууд дамжуулалт хийнэ.
<https://www.facebook.com/www.must.edu.mn>

“Нээлтийн ёслолын ажиллагаа”-ны ерөнхий зөвлөмж

Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, чанарын албуудад өгөх зөвлөмж:

- Бүрэлдэхүүн сургуулиудын Сургалт, чанарын алба элсэлт авсан хөтөлбөр бүрээс 2 оюутныг сонгон танхимын нээлтийн үйл ажиллагаанд оролцох урилга өгнө.
- Урилгыг Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний алба хэвлэж сургуулиудад хүргүүлнэ.
- Бүрэлдэхүүн сургуулиуд хичээлийн анги танхимуудад хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагааг үзэх техник хэрэгсэл, интернэт холболтыг бэлтгэнэ.
- Сургалт чанарын алба IX/04-ны өдрийн 11-12 цагийн хооронд лекцийн анги танхимуудад шинэ элсэгчдийг хуваарилж зөвлөх багшаар удирдуулан нээлтийн үйл ажиллагааг үзэх, оролцох боломжоор бүрдүүлнэ.

- 2 ба түүнээс дээш курсын оюутнууд тухайн цагт хичээл судалж байгаа анги танхимаасаа хичээл зааж байгаа багшийн хамт нээлтийн үйл ажиллагаа үзнэ.
- Бүрэлдэхүүн сургуулийн удирдлага, хөтөлбөр хариуцаж буй салбар тэнхимийн эрхлэгч нар өөрийн сургуулийн хамгийн олон оюутан багтах лекцийн танхим, клубээс нээлтийн үйл ажиллагаанд оролцож тухайн танхимд байгаа оюутнуудаар нэгдсэн хөтөлбөрийн дагуу “оюутны тангараг” өргүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- Бүрэлдэхүүн сургуулиуд элсэгчдэдээ зориулж өөрийн сургуулийн орчинд дурсгалын зураг татуулах боломж бүхий зориулалтын талбай засаж, анонс хэвлэж байрлуулах ажлыг хариуцна.

Оролцогчдод өгөх зөвлөмж:

- Хичээлийн жилийн нээлтийн танхимын үйл ажиллагаа 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 11:00 цагт эхэлнэ.
- Урилга авсан элсэгчид хүндэтгэлийн хувцастай ирэх ба нээлтийн ёслолын ажиллагаа эхлэхээс 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- Бусад элсэгчид, суралцагчид хуваарийн дагуу хичээлийн анги танхимуудад орж суудлаа эзэлсэн байна.
- Зарим анги танхимуудаас шууд дамжуулал хийж оюутнуудыг нээлтийн ёслолын ажиллагаанд оролцуулна.
- Элсэгчид, суралцагсад үндсэн арга хэмжээ дууссаны дараа тусгайлан зассан газруудад дурсгалын зураг татуулна.

ШУТИС-ИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2023 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн 11:00-12:05 цагт
ШУТИС-ийн төв байр 3 давхарт хурлын танхим

11:00-11:03	Нээлт
11:03-11:08	ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочид төлөөлөгчдийг танилцуулна.
11:08-11:18	Засгийн газрын төлөөлөл мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.
11:18-11:20	Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэнэ.
11:20-11:30	ШУТИС-ийн Захирал, доктор, профессор Т.Намнан хичээлийн шинэ жилийн ёслолын ажиллагааг нээж үг хэлнэ.
11:30-11:40	Шинэ элсэгчдэд тэтгэлэг, дурсгалын зүйлс гардуулна.
11:40-11:45	ШУТИС-д шинээр элсэгч оюутны төлөөлөл үг хэлнэ.
11:45-11:55	Цахим мэндчилгээ /видео шторк/
11:55-12:00	Ая дууны мэндчилгээ.
12:00-12:05	Шинэ элсэгчид Оюутны тангараг өргөнө.
12:05-12:10	Шинэ хичээлийн жилийн анхны хонх дуугаргана.
12:10-12:15	Нээлтийн ёслолын ажиллагааны хаалт /“ШУТИС-Бидний бахархал” дуу/